



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС - PMI

2025.I
улирал

2025 оны 4 дүгээр сар

МОНГОЛБАНК

Энэхүү үзүүлэлтийг олон улсад нийтлэг ашиглагддаг аргачлалын дагуу бодлого боловсруулагчид, бизнес эрхлэгчид болон олон нийтийн хэрэгцээнд зориулж улирлын давтамжтай тогтмол гаргаж байна.

1. Худалдан авалтын менежерийн индекс (PMI)

Ерөнхий индекс: Монгол Улсын худалдан авалтын менежерийн ерөнхий индексийн утга 2025 оны I улиралд тэлэлтийн мужид **51.2** гарлаа. PMI индекс нь сүүлийн 10 улирал дараалан тэлэлтийн мужид хэвээр хадгалагдсан боловч өмнөх улирлаас 7.3 нэгжээр буурсан байна. Ерөнхий индекс өмнөх улирлаас буурахад үйлдвэрлэл, шинэ захиалгын бууралт гол нөлөөг үзүүлсэн байна (Зураг 1-2).


Нийлмэл индекс: Нийлмэл индексүүдийн хувьд шинэ захиалгын индекс 7 улирлын дараа агших мужид шилжиж буурсан бол үйлдвэрлэлийн индекс сүүлийн 12, бараа материалын нөөц 9, ажил эрхлэлтийн индекс 6 улирал дараалан тэлэлтийн мужид гарлаа. Харин нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индекс 17 улирал дараалан агших мужид хэвээр байгаа байгаа бөгөөд өмнөх улирлын үр дүнтэй харьцуулахад бага зэрэг буурсан байна (Зураг 2).

Салбарын индекс: 2025 оны I улиралд дотоод худалдааны салбарын үзүүлэлт агших мужид шилжиж буурсан бол аж үйлдвэр, үйлчилгээний салбарын үзүүлэлт тэлэлтийн мужид, барилгын салбарын үзүүлэлт агших мужид хэвээр хадгалагдлаа. Тухайлбал, үйлчилгээний салбар сүүлийн 12, аж үйлдвэрийн салбар 4 улирал дараалан тэлэлтийн мужид, харин барилгын салбар 7 улирал дараалан агших мужид гараад байна. Өмнөх улирлын утгатай харьцуулахад бүх салбарын үзүүлэлт 0.2-11.3 нэгжээр тус тус буурсан байна (Зураг 3).


Зураг 1. Ерөнхий индекс



Зураг 2. Нийлмэл индекс



Зураг 3. Ерөнхий индекс, салбараар



Үйлдвэрлэлийн индексийн утгыг эдийн засгийн өсөлттэй (бодит ДНБ-ий жилийн өөрчлөлт) харьцуулахад үйлдвэрлэлийн индексийн утга 50-аас их гарсан дийлэнх үеүдэд эдийн засаг өсөлттэй гарчээ. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлийн индексийн утга нь бодит ДНБ-ий өсөлтийг тайлбарлах чадвар өндөр байна. Энэ улирлын үйлдвэрлэлийн индексийн утга 50.3 гарсан бөгөөд 2025 оны I улиралд эдийн засаг өсөлттэй гарах боловч өмнөх улирлын эдийн засгийн өсөлтийн хурдац саарах төлөвтэй байна (Зураг 4).

Зураг 4. Бодит ДНБ-ий улирлын өөрчлөлт болон үйлдвэрлэлийн индекс




2. Салбарын үзүүлэлтүүд

Аж үйлдвэр: 2025 оны I улиралд салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд шинэ захиалга, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт агших мужид, бусад үзүүлэлтүүд тэлэлтийн мужид гарсан байна. Өмнөх улирлын утгатай харьцуулахад ажил эрхлэлт 1.7 нэгжээр өссөн бол, үйлдвэрлэл 19.3, шинэ захиалга 18.9, бараа материалын нөөц 9.8, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 1.0 нэгжээр тус тус буурлаа (Зураг 5).

Аж үйлдвэрийн салбарын нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд худалдан авалтын тоо хэмжээ, бизнесийн үйл ажиллагааны төлөвийн үзүүлэлтээс бусад үзүүлэлтүүд тэлэлтийн мужид гарчээ. Өмнөх улиралтай харьцуулахад дуусаагүй үйлдвэрлэл 12.3, бүтээгдэхүүний үнэ 5.6 нэгжээр тус тус өслөө. Харин худалдан авалтын тоо хэмжээ 18.4, бизнесийн үйл ажиллагааны төлөв 16.7, бэлэн бүтээгдэхүүн болон түүхий эд материалын үнэ тус тус 1.9 нэгжээр буурсан байна /Хүснэгт 1/.

Зураг 5. Аж үйлдвэрийн салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр



Хүснэгт 1. Аж үйлдвэрийн салбарын нэмэлт үзүүлэлтүүд


Үзүүлэлт	2024 II	2024 III	2024 IV	2025 I
Дуусаагүй үйлдвэрлэл	61.5↑	55.9↓	48.3↓	60.6↑
Бэлэн бүтээгдэхүүн	65.3↑	54.6↓	67.2↑	65.3↓
Бүтээгдэхүүний үнэ	59.6↓	55.2↓	66.1↑	71.7↑
Худалдан авалтын тоо хэмжээ	63.0↑	70.6↑	60.7↓	42.3↓
Түүхий эд, материалын үнэ	81.2↑	66.8↓	89.1↑	87.2↓
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	60.0↑	65.2↑	65.0↓	48.3↓

Барилга: Тайлант улиралд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт тэлэлтийн мужаас агших мужид шилжиж буурснаас гадна нийт үзүүлэлтүүдийн утга буурч, агших мужид гарсан байна. Өмнөх улирлын утгатай харьцуулбал үйлдвэрлэлийн үзүүлэлт 31.6 нэгж, шинэ захиалга 20.7, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 13.5, бараа материалын нөөц 12.1, ажил эрхлэлт 1.2 нэгжээр тус тус буурчээ (Зураг 6).

Барилгын салбарын нэмэлт үзүүлэлтүүдийг авч үзвэл түүхий эд материалын үнэ, туслан гүйцэтгэгч ашиглалтын үзүүлэлтээс бусад үзүүлэлтүүд агших мужид гарчээ. Өмнөх улирлаас туслан гүйцэтгэгч ашиглалт 27.5, орон сууцны зах зээлийн идэвхжил 14.3, худалдан авалтын тоо хэмжээ 0.6 нэгжээр тус тус өссөн байна. Харин бизнесийн үйл ажиллагааны төлөв өмнөх улирлаас 14.6, барилга угсралтын үйл ажиллагаа 12.3, борлуулалтын үйл ажиллагаа 11.0, түүхий эд материалын үнэ 2.1 нэгжээр тус тус буурлаа /Хүснэгт 2/.

Дотоод худалдаа: 2025 оны I улиралд салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд бараа материалын нөөц, ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд тэлэлтийн мужид гарсан бол бусад үзүүлэлтүүд агших мужид гарлаа. Өмнөх улирлын утгатай харьцуулахад бараа материалын нөөц 10.5, ажил эрхлэлт 3.2 нэгжээр тус тус өссөн бол, харин шинэ захиалга 25.3 нэгж, үйлдвэрлэл 23.4 нэгжээр огцом буурсан байна. Мөн нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 4.3 нэгжээр өмнөх улирлаас буурчээ (Зураг 7).


Зураг 6. Барилгын салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр



Хүснэгт 2. Барилгын салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2024 II	2024 III	2024 IV	2025 I
Худалдан авалтын тоо хэмжээ	47.3↓	36.1↓	46.2↑	46.8↑
Түүхий эд, материалын үнэ	71.9↓	94.6↑	95.8↑	93.7↓
Орон сууцны зах зээлийн идэвхжил	62.5↑	45.4↓	32.8↓	47.1↑
Борлуулалтын үйл ажиллагаа	46.2↑	20.9↓	42.3↑	31.3↓
Барилга, угсралтын үйл ажиллагаа	47.6↓	47.8↑	32.7↓	20.5↓
Туслан гүйцэтгэгч ашиглалт	56.0↑	76.0↑	46.8↓	74.3↑
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	42.2↓	24.8↓	55.8↑	41.2↓

Зураг 7. Дотоод худалдааны салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр



Нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд хүлээгдэж буй борлуулалтын үзүүлэлтээс бусад 2 үзүүлэлт тэлэлтийн мужид гарчээ. Өмнөх улиралтай харьцуулахад түүхий эд материалын үнэ 6.0, худалдан авсан барааны хэмжээ 1.0 нэгжээр тус тус өсөж, уг судалгаа эхэлснээс хойш 17 улирал дараалан тэлэлтийн мужид гарлаа. Хүлээгдэж буй борлуулалтын үзүүлэлт өмнөх улирлаас 24.7 нэгжээр буурснаар сүүлийн 11 улирал дараалан агших мужид гарсан нь салбарын хүлээлт сайжрахгүй байгааг илтгэж байна /Хүснэгт 3/.


Үйлчилгээ: Салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд үйлдвэрлэл (бизнесийн идэвхжил) сүүлийн 12 улирал, шинэ захиалга сүүлийн 10 улирал дараалан тэлэлтийн мужид гарлаа. Ажил эрхлэлт тэлэлтийн мужид шилжиж сайжирсан байна. Харин нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт агших мужид гарсан байна. Өмнөх улирлын утгатай харьцуулахад ажил эрхлэлт 5.5, шинэ захиалга 5.4 нэгжээр өссөн бол, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 9.2, үйлдвэрлэл 5.8 нэгжээр тус тус буурчээ (Зураг 8).

Үйлчилгээний салбарын нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд дуусаагүй ажил, үйлчилгээний үзүүлэлт өмнөх улирлаас 14.1, түүхий эд, материалын үнийн үзүүлэлт 3.6, үйлчилгээний үнэ 1.2 нэгжээр тус тус өссөнөөс гадна тэлэлтийн мужид хэвээр хадгалагдсан байна. Мөн бизнесийн үйл ажиллагааны төлөвийн үзүүлэлт өмнөх улирлаас 8.3 нэгжээр буурсан хэдий ч сүүлийн 10 улирал дараалан тэлэлтийн мужид гарлаа /Хүснэгт 4/.

Хүснэгт 3. Дотоод худалдааны салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2024 II	2024 III	2024 IV	2025 I
Түүхий эд, материалын үнэ	70.5↓	83.6↑	81.1↓	87.1↑
Худалдан авсан барааны хэмжээ	77.0↓	91.3↑	82.8↓	83.8↑
Хүлээгдэж буй борлуулалт	30.0↑	32.5↑	31.7↓	7.0↓

Зураг 8. Үйлчилгээний салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр



Хүснэгт 4. Үйлчилгээний салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2024 II	2024 III	2024 IV	2025 I
Түүхий эд, материалын үнэ	76.8↓	58.0↓	75.1↑	78.7↑
Үйлчилгээний үнэ	59.9↓	44.1↓	73.7↑	74.9↑
Дуусаагүй ажил үйлчилгээ	57.1↑	41.8↓	46.4↑	60.5↑
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	60.1↓	74.8↑	66.9↓	58.6↓


3. PMI индекс ААН-ийн ажиллагсдын тооны бүлгээр

Ажиллагсдын тооны бүлэг: Аж ахуйн нэгжүүдийг ажилчдын тоогоор жижиг (50 хүртэл), дунд (50-199), том (200-с дээш) гэж ангилан тайлант улирлын худалдан авалтын менежерийн индексийн утгыг тооцвол том ААН-үүдийн индексийн утга 12 улирал дараалан тэлэлтийн мужид, дунд ААН-үүдийн индексийн утга агших мужид шилжсэн бол жижиг ААН-үүдийн индексийн утга 17 улирал дараалан агших мужид гарлаа. Харин индексийн утгыг өмнөх улиралтай харьцуулахад том ААН-үүд 9.3, жижиг ААН-үүд 6.5, дунд ААН-үүдийн үзүүлэлт 5.5 нэгжээр тус тус буурч, харгалзан 53.9, 44.6, 39.4 гарлаа. (Зураг 9).


Жижиг: ААН-үүдийн хувьд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт 9.8 нэгжээр өсөж тэлэлтийн мужид гарсан бол бусад бүх үзүүлэлт агших мужид гарсан байна. Өмнөх улиралтай харьцуулахад үйлдвэрлэл 13.8, бараа материалын нөөц 12.7, ажил эрхлэлт 6.7, шинэ захиалга 6.2 нэгжээр тус тус буурч агших мужид гарлаа (Зураг 10).

Дунд: ААН-үүдийн хувьд энэ улиралд бараа материалын нөөцийн үзүүлэлтээс бусад бүх үзүүлэлт агших мужид гарсан байна. Үйлдвэрлэл 10.7, ажил эрхлэлт 3.6 нэгжээр тус тус буурснаар агших мужид шилжсэн. Харин шинэ захиалга, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлтүүд агших мужид хэвээр гарсан байна. Өмнөх улирлын утгатай харьцуулахад нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 0.9 нэгжээр өссөн бол шинэ захиалга 6.7, бараа материалын нөөц 1.7 нэгжээр буурсан байна (Зураг 11).


Зураг 9. Байгууллагын хэмжээгээр



Зураг 10. Жижиг ААН-үүд, үзүүлэлтүүдээр




Зураг 11. Дунд ААН-үүд үзүүлэлтүүдээр




Том: ААН-үүдийн хувьд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт эргэн агших мужид шилжсэн бол ажил эрхлэлтийн үзүүлэлт сүүлийн 15, шинэ захиалга болон үйлдвэрлэлийн үзүүлэлт тус бүр 12, бараа материалын нөөц 9 улирал дараалан тэлэлтийн мужид хэвээр гарлаа. Өмнөх улирлын утгатай харьцуулахад ажил эрхлэлт 4.6 нэгжээр өссөн бол харин үйлдвэрлэл 17.5, шинэ захиалга 12.1, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 11.7, бараа материалын нөөц 4.6 нэгжээр тус тус буурчээ (Зураг 12).

Зураг 12. Том ААН-үүд үзүүлэлтүүдээр



4. Олон улсын PMI индекс

Зураг 13. Монгол болон худалдааны голлох түнш улсуудын PMI



Худалдааны голлох түнш улсуудын PMI¹: 2025 оны I улиралд манай худалдааны голлох түнш улсуудын PMI индекс өмнөх улирлаас Евро бүс, Хятадыг эс тооцвол бага зэрэг буурсан боловч бүгд тэлэлтийн мужид гарлаа. Тухайлбал Евро бүсийн ерөнхий индексийн утга сүүлийн 7 сарын хамгийн өндөр түвшинд хүрч, тэлэлтийн мужид шилжин 50.9 гарлаа. Үйлдвэрлэл өссөнөөс гадна гадна ажил эрхлэлт өнгөрсөн оны 7 сараас хойш анх удаа өсжээ. БНХАУ-ын нийт бизнесийн идэвхжил өнгөрсөн оны 11 сараас хойших хамгийн хурдацтай өсөлтийг үзүүлж 51.8 гарсан байна. Үүнд аж үйлдвэр, үйлчилгээний салбарын аль алинд үйлдвэрлэл хурдацтай өссөн нь нөлөөлжээ. Мөн шинэ захиалга, экспортын шинэ захиалга, дуусаагүй үйлдвэрлэл нэмэгдсэн байна. ОХУ-ын бизнесийн идэвхжил өмнөх улирлаас бага зэрэг саарч 50.1 гарсан байна. Үүнд үйлчилгээний салбарын үйлдвэрлэл зогсонги байдалд орсон нь нөлөөлжээ. Шинэ захиалгын өсөлт саарч, ажил эрхлэлт сүүлийн 2 жилийн хамгийн хурдацтай

¹ Голлох түнш улсуудын PMI индексийн тухайн улирлын сүүлийн сарын үзүүлэлтээр тооцсон болно.

буурсан бол бүтээгдэхүүний үнэ 2021 оны 1 сараас хойших хамгийн сул өсөлтийг үзүүлжээ. АНУ-ын PMI ерөнхий индекс 53.5 гарсан бөгөөд бизнесийн идэвхжил тогтвортой өсөлттэй байна. Шинэ захиалга, үнэ нэмэгдэж байгаагаас гадна үйлдвэрлэлийн зардал сүүлийн 2 жилийн хамгийн хурдацтай өсөлтийг үзүүлсэн байна. Дэлхийн үйлдвэрлэл сүүлийн 26 сарын туршид тэлэлтийн мужид, сүүлийн 4 сарын хамгийн хурдацтай өсөлттэй 52.1 гарсан байна. Үйлдвэрлэл, шинэ захиалга, түүхий эдийн зардал хурдацтай өсжээ. Үйлчилгээний салбарын бизнесийн идэвхжил аж үйлдвэрийн салбарын өсөлтөөс илүү өсөлттэй гарлаа.

ААН-ийн ерөнхий мэдээлэл

Судалгааны түүвэрлэлт хийхдээ аж үйлдвэр, барилга, дотоод худалдаа (бөөний болон жижиглэн) болон үйлчилгээний салбаруудаас идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй, эх олонлогийг төлөөлөхүйц 387 ААН-ийг **жижиг** (49 хүртэл ажилтантай), **дунд** (50-199 хүртэл ажилтантай), **том** (200-с дээш ажилтантай) гэж ангилан түүвэрлэлт хийсэн бөгөөд ингэхдээ тухайн ангилалд хамаарах бүх аж ахуйн нэгжүүдээс жилийн борлуулалтын орлогоор тэргүүлэх аж ахуйн нэгжүүдийг түүвэрт сонголоо.

Санал асуулгыг **2025 оны 4-р сард нийт 387** аж ахуйн нэгжийн дунд явуулсан бөгөөд **аж үйлдвэрийн салбарын 135, барилгын салбарын 80, дотоод худалдааны салбарын 66, үйлчилгээний салбарын 106** аж ахуйн нэгж судалгаанд хамрагдлаа. Ажилчдын тоогоор жижиг ангилалд хамаарах 276 (71%), дунд 83 (21%), том 28 (7%) аж ахуйн нэгжүүд судалгаанд оролцлоо /Хүснэгт 1/.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тоо, салбар, ажилтны тооны бүлгээр²

Ерөнхий салбар	Салбар	ААН-ийн тоо 2025.1*	Жижиг	Дунд	Том	Нийт	Эзлэх хувь
Аж үйлдвэр (135)	Уул уурхай, олборлолт	1,213	2	3	4	9	2%
	Боловсруулах үйлдвэрлэл	7,746	88	21	10	119	31%
	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	296	2	-	2	4	1%
	Усан хангамж	243	1	2	-	3	1%
	Барилга	8,611	66	11	3	80	21%
Дотоод худалдаа	Бөөний болон жижиглэн худалдаа	41,830	52	11	3	66	17%
Үйлчилгээ (106)	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	4,094	10	5	-	15	4%
	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	2,939	6	4	-	10	3%
	Мэдээлэл, холбоо	3,062	5	3	2	10	3%
	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2,091	5	7	-	12	3%
	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1,279	8	1	1	10	3%
	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн ү.а	6,806	1	-	-	1	0%
	Боловсрол	3,910	2	4	1	7	2%
	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2,854	5	3	1	9	2%
	Урлаг, үзвэр, тоглоом наадам	1,175	-	1	-	1	0%
	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	9,183	23	7	1	31	8%
Нийт		97,332	276	83	28	387	100%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

² 2025 оны I улирлын байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн тоо

Жилийн борлуулалтын орлогоор ангилан авч үзвэл 50 хүртэл сая төгрөгийн 19 (5%), 50-300 сая төгрөгийн 44 (11%), 300 саяас 1 тэрбум төгрөгийн 72 (19%), 1-2.5 тэрбум төгрөгийн 70 (18%), 2.5-с дээш тэрбум төгрөгийн орлоготой 182 (47%) аж ахуйн нэгж судалгаанд хамрагджээ /Хүснэгт 2/.

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тоо, салбар, жилийн борлуулалтын орлогын бүлгээр

Ерөнхий салбар	Салбар	Жижиг	Дунд	Том	Нийт	Эзлэх хувь
Аж үйлдвэр	50 сая₮ хүртэл	11			11	3%
	50-300 сая₮ хүртэл	15			15	4%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	31	1		32	8%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	16	3	1	20	5%
	2.5 тэрбум₮ дээш	20	22	15	57	15%
Барилга	50 сая₮ хүртэл				-	0%
	50-300 сая₮ хүртэл	7			7	2%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	15			15	4%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	18			18	5%
	2.5 тэрбум₮ дээш	26	11	3	40	10%
Дотоод худалдаа	50 сая₮ хүртэл	1			1	0%
	50-300 сая₮ хүртэл	8			8	2%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	12			12	3%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	9			9	2%
	2.5 тэрбум₮ дээш	22	11	3	36	9%
Үйлчилгээ	50 сая₮ хүртэл	7			7	2%
	50-300 сая₮ хүртэл	14			14	4%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	13			13	3%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	19	4		23	6%
	2.5 тэрбум₮ дээш	12	31	6	49	13%
Нийт	50 сая₮ хүртэл	19	-	-	19	5%
	50-300 сая₮ хүртэл	44	-	-	44	11%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	71	1	-	72	19%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	62	7	1	70	18%
	2.5 тэрбум₮ дээш	80	75	27	182	47%
Нийт		276	83	28	387	100%

Худалдан авалтын менежерийн индексийн тухай

Худалдан авалтын менежерийн индекс (PMI) нь бодлого боловсруулагчид, хөрөнгө оруулагчид болон аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудын хувьд эдийн засаг, бизнесийн төлөв байдлыг харах, үйл ажиллагаагаа удирдах, төлөвлөх, урьдчилан таамаглах, шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой үзүүлэлт болдог. PMI нь тооцоход хялбар энгийн аргачлал дээр үндэслэгдэж, албан ёсны статистик тоон мэдээлэл гарахаас өмнө эдийн засаг, бизнесийн төлөв байдлыг тодорхойлохын зэрэгцээ бусад орнуудтай харьцуулалт хийх боломж олгодгоороо давуу талтай. Олон улсын туршлагаас харахад уг индексийг тооцохдоо эдийн засгийн голлох салбаруудын нөлөө бүхий 400 орчим аж ахуйн нэгжүүдийг сонгон түүвэрлэлтэд хамруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, шинэ захиалга, ажил эрхлэлт, бараа материалын нөөц, хүргэлтийн хугацаа болон бусад үзүүлэлтийн талаарх мэдээллийг судалж, эдгээр үзүүлэлт бүрээр индексийн утгыг тооцон, индексийн өөрчлөлтийг харгалзан дүгнэлт өгдөг.

“Худалдан авалтын менежерийн индекс (Purchasing manager index-PMI)” нь эдийн засгийн ерөнхий хандлагыг харуулсан чиглэлийн индекс юм.

Аргачлал: Түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс үзүүлэлт тус бүрийн хувьд өмнөх улирлаас хэрхэн өөрчлөгдсөн талаар чанарын асуулт асууж, хариултуудыг нэгтгэх замаар тоон буюу индексийн утгад шилжүүлнэ. Индексийг үзүүлэлт тус бүрээр тооцон гаргаж салбаруудын индекс, нийлмэл индекс, нийт эдийн засгийн индексийг тооцоолоход ашиглана.

$$\text{PMI (тухайн үзүүлэлтийн тархалтын индекс)} = (K1 * 1) + (K2 * 0.5) + (K3 * 0)$$

$k1$ = Өссөн гэсэн хариултын хувь

$k2$ = Хэвэндээ гэсэн хариултын хувь

$k3$ = Буурсан гэсэн хариултын хувь

Уг индексийн тооцоолсон утгыг **тархалтын индекс** гэж нэрлэх бөгөөд PMI=50 бол бизнесийн үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүйг, PMI>50 бол бизнесийн үйл ажиллагааны тэлэлтийг, PMI<50 бол агшилтыг тус тус илэрхийлдэг. Энэхүү утга 50-аас холдох тусам тэлэлт эсвэл агшилт ихэснэ. Тодруулбал, PMI-ийн үзүүлэлт өмнөх улирлын үзүүлэлтээс өндөр байвал эдийн засаг илүү хурдтай тэлж (агшиж) байгааг, харин өмнөх улирлаас доогуур байвал илүү багаар тэлж (агшиж) байна гэсэн утгыг илэрхийлнэ.

Энэхүү судалгаанд PMI-ийг эдийн засгийн голлох салбаруудаар тооцохын зэрэгцээ аж ахуйн нэгжийн ажилчдын тоог нь харгалзан жижиг (49 хүртэл), дунд (50-199), том (200-с дээш) гэж ангилан, бүлэг тус бүрээр индексийг тооцож гаргасан. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлогын нийт борлуулалтын орлогод эзлэх хувиар нь бүлэг тус бүрийн үзүүлэлтийн тархалтын индексийг жигнэж тухайн үзүүлэлтийн салбар бүр дэх индексийн утгыг тооцлоо. Салбар болон нийт эдийн засгийн PMI-ийг тооцохдоо гол үзүүлэлтүүдийн нийлмэл³ индексийг олон улсад нийтлэг ашиглагддаг ач холбогдлын жингээр⁴ жигнэн тооцсон болно.

³ Салбар бүр дэх гол 5 үзүүлэлтүүдийн индексийг ДНБ-д эзлэх хувиар жигнэн тооцсон үзүүлэлт болно.

⁴ Олон улсын туршлагаар PMI-ийг тооцохдоо шинэ захиалга 30%, үйлдвэрлэлийн хэмжээ 25%, ажил эрхлэлт 20%, нийлүүлэлт хугацаа 15%, бараа материалын нөөц 10%-иар жигнэж тооцдог байна. An introduction to the PMI surveys, IHS Markit.

Аж үйлдвэр

Үзүүлэлт	2023.I	2023.II	2023.III	2023.IV	2024.I	2024.II	2024.III	2024.IV	2025.I
Аж үйлдвэр	54.2	59.0	58.2	62.1	49.2	57.9	63.2	63.4	52.1
Шинэ захиалга	47.9	62.6	63.7	64.0	43.1	53.9	63.9	61.7	42.8
Үйлдвэрлэл	55.0	65.9	61.6	68.1	45.5	69.1	73.0	70.1	50.8
Ажил эрхлэлт	59.3	53.6	55.2	69.7	59.1	57.2	67.5	64.7	66.4
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	54.2	44.8	47.3	43.3	44.3	45.5	36.8	48.1	47.1
Түүхий эд, материалын нөөц	61.0	63.4	56.0	54.5	64.2	61.4	67.4	72.0	62.2
Жижиг									
Шинэ захиалга	41.1	52.1	44.7	43.7	48.8	44.0	49.4	42.5	38.0
Үйлдвэрлэл	42.1	49.3	50.0	44.1	47.6	42.2	51.3	48.9	34.4
Ажил эрхлэлт	41.4	39.7	41.1	42.3	47.6	41.2	51.9	49.0	37.8
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	52.6	58.8	50.6	50.0	53.1	41.7	39.3	52.8	57.4
Түүхий эд, материалын нөөц	42.0	43.1	51.3	46.7	48.0	48.0	57.9	55.7	39.2
Дуусаагүй үйлдвэрлэл	51.3	54.4	51.7	48.1	48.5	48.9	54.6	53.2	47.0
Бэлэн бүтээгдэхүүн	43.9	50.0	54.7	46.7	50.7	47.0	54.7	46.0	40.6
Бүтээгдэхүүний үнэ	72.2	69.1	68.8	64.9	60.2	62.7	71.4	70.3	68.3
Худалдан авалтын тоо хэмжээ	39.9	46.7	46.7	49.4	43.5	39.0	52.6	45.5	34.7
Түүхий эд, материалын үнэ	85.8	84.5	79.6	80.4	72.9	76.0	86.2	85.3	85.2
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	57.1	51.5	51.7	50.6	43.5	52.1	54.1	58.4	44.1
Дунд									
Шинэ захиалга	51.0	53.4	58.6	63.6	60.0	48.0	42.9	43.8	41.3
Үйлдвэрлэл	53.9	62.1	56.7	71.2	58.1	60.4	55.0	48.1	42.0
Ажил эрхлэлт	52.9	43.1	41.1	60.0	58.5	54.0	40.9	53.8	44.2
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	43.9	43.1	46.6	46.9	46.4	36.0	47.5	50.0	45.8
Түүхий эд, материалын нөөц	50.0	59.1	53.7	54.5	55.3	46.0	38.1	52.0	44.0
Дуусаагүй үйлдвэрлэл	46.7	62.1	64.3	63.6	55.3	60.4	65.0	52.2	42.9
Бэлэн бүтээгдэхүүн	55.1	52.3	51.9	51.6	59.2	58.0	54.8	52.0	46.0
Бүтээгдэхүүний үнэ	79.4	71.7	63.3	69.7	68.3	66.0	54.8	71.2	72.0
Худалдан авалтын тоо хэмжээ	50.0	47.8	64.8	56.1	51.2	50.0	50.0	56.0	42.0
Түүхий эд, материалын үнэ	93.0	86.7	77.6	87.1	79.1	76.0	78.6	84.6	86.0
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	63.0	52.2	63.8	51.5	51.2	56.3	60.5	52.0	60.4
Том									
Шинэ захиалга	47.9	64.7	65.8	65.4	40.0	55.6	68.2	65.8	43.3
Үйлдвэрлэл	56.0	67.6	63.2	69.2	43.3	72.2	77.3	75.0	53.3
Ажил эрхлэлт	61.5	56.3	58.3	73.1	60.0	58.8	72.7	67.5	71.9
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	56.0	44.1	47.2	42.3	43.3	47.2	35.0	47.5	46.7
Түүхий эд, материалын нөөц	64.0	65.4	56.7	55.0	66.7	64.7	72.7	76.3	66.7
Дуусаагүй үйлдвэрлэл	52.2	64.7	61.1	61.5	46.4	62.5	54.5	47.4	64.3
Бэлэн бүтээгдэхүүн	65.4	61.5	66.7	55.0	56.7	67.6	54.5	71.1	70.0
Бүтээгдэхүүний үнэ	80.0	61.8	69.4	69.2	66.7	58.3	54.2	65.0	71.9
Худалдан авалтын тоо хэмжээ	53.8	53.6	73.3	60.0	40.0	66.7	75.0	62.5	42.9
Түүхий эд, материалын үнэ	86.5	82.4	89.5	80.8	80.0	82.4	63.6	90.0	87.5
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	53.8	53.1	50.0	88.5	40.0	61.1	66.7	67.5	46.7

Барилга

Үзүүлэлт	2023.I	2023.II	2023.III	2023.IV	2024.I	2024.II	2024.III	2024.IV	2025.I
Барилга	44.5	53.7	42.1	37.3	49.6	47.6	45.2	47.8	30.2
Шинэ захиалга	35.4	54.4	41.1	21.9	42.7	36.3	31.6	48.1	27.4
Үйлдвэрлэл	40.8	51.2	44.2	38.1	57.8	62.0	73.4	47.4	15.9
Ажил эрхлэлт	59.3	61.2	36.8	47.1	51.4	49.2	34.4	46.7	45.6
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	48.4	51.7	42.0	53.5	51.3	49.4	50.7	51.8	38.3
Түүхий эд, материалын нөөц	45.0	45.4	51.2	37.5	43.9	39.2	28.9	43.6	31.4
Жижиг									
Шинэ захиалга	39.3	40.9	34.2	35.9	40.1	48.1	45.8	45.4	39.7
Үйлдвэрлэл	47.5	43.4	34.4	44.9	48.2	57.1	52.0	42.9	42.3
Ажил эрхлэлт	41.1	34.8	25.0	46.8	45.1	39.7	43.8	36.6	45.5
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	54.5	52.8	48.0	56.8	52.1	44.0	45.6	53.8	50.0
Түүхий эд, материалын нөөц	38.6	35.4	50.7	39.1	40.8	46.4	38.0	45.4	44.5
Худалдан авалтын тоо хэмжээ	42.2	38.6	39.2	44.9	44.9	48.1	51.1	50.0	41.3
Түүхий эд, материалын үнэ	89.8	88.1	89.4	85.6	82.9	79.6	77.7	89.1	83.3
Орон сууцны зах зээлийн идэвхжил	33.3	43.1	31.5	39.0	50.7	52.2	51.1	45.5	53.1
Борлуулалтын үйл ажиллагаа	67.8	37.7	35.2	41.1	38.4	42.0	45.7	41.5	39.3
Барилга, угсралтын үйл ажиллагаа	41.2	40.8	47.4	39.9	46.0	57.7	51.0	44.2	47.5
Туслан гүйцэтгэгч ашиглалт	47.1	46.9	46.0	50.9	42.3	50.0	45.7	46.9	49.1
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	53.3	56.4	59.9	53.8	49.3	39.7	45.7	63.7	53.3
Дунд									
Шинэ захиалга	42.9	56.3	29.2	27.8	30.0	30.8	31.3	46.9	20.0
Үйлдвэрлэл	50.0	44.0	41.7	48.2	52.3	57.1	38.9	46.7	22.7
Ажил эрхлэлт	62.0	48.1	34.0	41.4	50.0	57.1	45.0	50.0	36.4
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	54.0	54.0	54.3	57.7	42.9	53.6	57.1	53.6	54.5
Түүхий эд, материалын нөөц	56.0	45.8	54.3	30.8	34.2	26.9	27.8	28.1	31.8
Худалдан авалтын тоо хэмжээ	52.0	43.8	45.7	51.9	41.3	58.3	44.4	34.4	45.5
Түүхий эд, материалын үнэ	92.0	90.4	88.6	91.1	86.4	75.0	100.0	93.8	90.9
Орон сууцны зах зээлийн идэвхжил	35.3	41.7	35.7	30.0	32.4	57.1	30.0	36.7	35.0
Борлуулалтын үйл ажиллагаа	73.1	36.7	44.4	37.5	36.8	42.3	40.0	26.7	36.4
Барилга, угсралтын үйл ажиллагаа	58.8	41.7	39.6	39.7	44.4	50.0	40.0	37.5	36.4
Туслан гүйцэтгэгч ашиглалт	50.0	30.8	37.5	56.8	50.0	57.1	55.6	40.0	45.5
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	53.8	54.0	43.5	48.1	52.5	45.8	56.3	60.0	45.5
Том									
Шинэ захиалга	30.0	60.0	50.0	12.5	50.0	33.3	25.0	50.0	25.0
Үйлдвэрлэл	33.3	58.3	50.0	30.0	65.0	66.7	100.0	50.0	0.0
Ажил эрхлэлт	66.7	80.0	43.8	50.0	55.0	50.0	25.0	50.0	50.0
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	42.9	50.0	33.3	50.0	55.0	50.0	50.0	50.0	25.0
Түүхий эд, материалын нөөц	42.9	50.0	50.0	40.0	50.0	41.7	25.0	50.0	25.0
Худалдан авалтын тоо хэмжээ	33.3	50.0	50.0	50.0	55.0	41.7	25.0	50.0	50.0
Түүхий эд, материалын үнэ	100.0	75.0	75.0	80.0	77.8	66.7	100.0	100.0	100.0
Орон сууцны зах зээлийн идэвхжил	50.0	50.0	83.3	10.0	60.0	70.0	50.0	25.0	50.0
Борлуулалтын үйл ажиллагаа	78.6	50.0	42.9	30.0	44.4	50.0	0.0	50.0	25.0
Барилга, угсралтын үйл ажиллагаа	25.0	66.7	62.5	40.0	60.0	41.7	50.0	25.0	0.0
Туслан гүйцэтгэгч ашиглалт	50.0	60.0	50.0	40.0	62.5	58.3	100.0	50.0	100.0
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	62.5	58.3	37.5	40.0	55.6	41.7	0.0	50.0	33.3

Дотоод худалдаа

Үзүүлэлт	2023.I	2023.II	2023.III	2023.IV	2024.I	2024.II	2024.III	2024.IV	2025.I
Дотоод худалдаа	56.0	52.9	54.8	53.3	52.5	54.8	50.8	53.6	41.3
Шинэ захиалга	54.1	54.3	60.8	51.5	51.0	54.2	56.2	57.4	32.1
Үйлдвэрлэл	68.1	72.5	63.9	57.5	55.1	71.5	60.2	54.7	31.4
Ажил эрхлэлт	53.7	41.3	43.7	53.9	55.4	50.2	43.8	48.2	51.4
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	42.4	32.1	46.5	56.3	39.8	42.3	39.2	53.0	48.7
Түүхий эд, материалын нөөц	56.4	53.8	48.7	42.4	63.4	42.6	42.0	51.4	61.9
Жижиг									
Шинэ захиалга	46.5	45.8	48.1	48.0	40.9	51.3	42.5	41.2	32.0
Үйлдвэрлэл	50.7	54.3	57.9	53.2	42.5	56.4	44.3	39.0	27.5
Ажил эрхлэлт	40.8	39.6	43.2	46.8	46.9	43.8	49.1	39.8	45.2
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	46.9	45.7	46.9	52.1	53.9	41.3	47.0	50.0	61.7
Түүхий эд, материалын нөөц	44.8	40.7	47.0	37.9	54.5	47.5	43.6	38.0	36.2
Худалдан авсан барааны дундаж үнэ	81.9	79.2	76.8	81.9	69.2	73.8	80.2	70.2	74.0
Худалдан авсан барааны хэмжээ	88.4	54.3	74.6	66.9	70.7	78.8	82.4	69.0	69.1
Хүлээгдэж буй борлуулалт	26.3	33.0	36.9	32.7	35.5	30.0	16.7	24.6	16.3
Дунд									
Шинэ захиалга	54.5	53.8	61.5	42.3	56.0	69.2	50.0	59.1	30.0
Үйлдвэрлэл	69.2	59.1	67.9	42.3	54.0	65.4	66.7	50.0	36.4
Ажил эрхлэлт	65.4	42.3	46.7	57.7	52.1	65.4	44.4	63.6	68.2
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	50.0	31.8	38.5	38.5	27.1	45.8	50.0	40.9	50.0
Түүхий эд, материалын нөөц	62.5	62.5	50.0	62.5	77.1	50.0	72.2	60.0	77.8
Худалдан авсан барааны дундаж үнэ	72.7	73.1	90.0	82.1	80.0	70.8	83.3	68.2	90.9
Худалдан авсан барааны хэмжээ	90.9	77.3	86.4	87.5	82.0	76.9	94.4	80.0	85.0
Хүлээгдэж буй борлуулалт	34.6	34.6	33.3	29.2	27.1	23.1	33.3	36.4	0.0
Том									
Шинэ захиалга	62.5	64.3	75.0	60.0	60.0	50.0	75.0	75.0	33.3
Үйлдвэрлэл	87.5	100.0	68.8	70.0	70.0	91.7	75.0	75.0	33.3
Ажил эрхлэлт	62.5	42.9	42.9	60.0	66.7	50.0	37.5	50.0	50.0
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	33.3	16.7	50.0	70.0	30.0	41.7	25.0	62.5	33.3
Түүхий эд, материалын нөөц	66.7	64.3	50.0	37.5	66.7	33.3	25.0	62.5	83.3
Худалдан авсан барааны дундаж үнэ	62.5	50.0	100.0	90.0	80.0	66.7	87.5	100.0	100.0
Худалдан авсан барааны хэмжээ	75.0	64.3	85.7	50.0	90.0	75.0	100.0	100.0	100.0
Хүлээгдэж буй борлуулалт	50.0	64.3	56.3	50.0	20.0	33.3	50.0	37.5	0.0

Үйлчилгээ

Үзүүлэлт	2023.I	2023.II	2023.III	2023.IV	2024.I	2024.II	2024.III	2024.IV	2025.I
Үйлчилгээ	54.8	53.5	53.9	59.8	54.1	58.7	63.3	54.7	54.5
Шинэ захиалга	52.2	54.0	52.8	65.1	59.3	61.2	61.3	53.7	59.1
Борлуулалтын орлого	66.2	59.1	63.9	59.9	57.5	66.3	75.9	64.7	58.9
Ажил эрхлэлт	58.9	51.7	43.8	56.9	47.5	58.6	62.8	49.3	54.7
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	36.5	46.4	53.3	53.5	47.8	42.1	48.0	48.0	38.8
Жижиг									
Шинэ захиалга	46.2	49.6	44.9	45.9	51.0	38.4	42.3	40.0	33.0
Борлуулалтын орлого	50.0	53.3	50.7	54.0	50.0	40.9	45.8	44.9	30.3
Ажил эрхлэлт	40.1	42.5	42.9	48.0	49.5	43.9	38.9	45.5	38.7
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	51.4	49.2	49.1	46.4	49.4	40.4	53.0	47.5	63.7
Түүхий эд, материалын үнэ	85.0	87.0	81.5	76.8	77.3	72.5	75.8	81.8	81.8
Үйлчилгээний үнэ	68.5	67.9	64.2	63.5	63.9	64.3	70.7	69.2	68.1
Дуусаагүй ажил үйлчилгээ	55.1	71.8	44.8	68.0	56.1	60.6	60.0	53.2	56.3
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	59.9	51.7	52.8	46.2	56.3	42.6	50.0	54.1	45.6
Дунд									
Шинэ захиалга	45.3	60.3	54.8	57.5	52.3	58.9	51.9	48.5	45.6
Борлуулалтын орлого	51.4	60.3	53.6	58.3	65.1	69.1	64.8	60.0	45.7
Ажил эрхлэлт	51.4	52.6	44.2	54.8	59.3	54.3	61.1	48.6	50.0
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	59.4	50.0	42.1	48.8	39.5	43.0	38.6	41.4	45.7
Түүхий эд, материалын үнэ	92.2	85.7	85.7	83.8	82.5	76.2	76.9	84.4	90.0
Үйлчилгээний үнэ	66.7	70.0	70.2	59.8	63.1	58.9	68.5	71.4	77.9
Дуусаагүй ажил үйлчилгээ	53.7	83.3	48.7	63.2	62.8	59.8	61.9	59.3	55.6
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	65.3	59.7	61.5	65.0	67.5	62.0	57.4	57.6	65.6
Том									
Шинэ захиалга	55.0	52.8	53.3	70.0	62.5	65.0	66.7	57.1	66.7
Борлуулалтын орлого	72.7	59.5	68.8	61.1	56.3	69.0	83.3	68.8	66.7
Ажил эрхлэлт	63.6	52.6	43.8	58.8	43.8	61.9	66.7	50.0	58.3
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	27.8	45.0	57.1	55.9	50.0	42.1	50.0	50.0	33.3
Түүхий эд, материалын үнэ	80.0	85.0	78.6	83.3	87.5	77.5	50.0	71.4	75.0
Үйлчилгээний үнэ	72.7	71.4	75.0	75.0	68.8	59.5	33.3	75.0	75.0
Дуусаагүй ажил үйлчилгээ	44.4	67.6	65.4	69.2	50.0	55.9	33.3	41.7	62.5
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	77.3	55.3	68.8	73.3	68.8	61.9	83.3	71.4	58.3